

**ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ МЭДЛЭГИЙГ ҮНЭЛЭХ
ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР ГҮЙЦЭТГЭЛИЙГ ДҮГНЭСЭН АРГАЧЛАЛ**

№	Шалгах үзүүлэлт	Даалгаврын гүйцэтгэл	Өгөх үнэлгээ
1	Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргахад хуулиар тогтоосон хэлбэр, агуулгын шаардлагыг хангасан байдал (ҮХЦМХШАмХ-ийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг)		
	- нэр, хаяг, оршин суугаа газар, харилцах хэлбэрийг бүрэн тусгасан эсэх	Мэдээлэл гаргагч: Монгол Улсын иргэн ... овогт ...-ийн-ийн Т Оршин суугаа хаяг: Улаанбаатар хот, ... дүүрэг, ... дугаар хороо, ... тоот Утасны дугаар: ... Цахим шуудан: ...	
	- Үндсэн хуульд нийцээгүй гэж үзэж байгаа хууль тогтоомжийн нэр, батлан гаргасан он, сар, өдөр, дугаар, түүнчлэн Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаа этгээдийн хаяг үйл ажиллагааны талаар тусгасан эсэх	Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталж, 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсөн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн. Үндсэн хууль зөрчсөн этгээд нь Улаан баатар хот, ... дүүрэг, ... дугаар хороо, Төрийн ордон хаягт байрлах Монгол Улсын Их хурал болно.	
	- Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн ямар зүйл, хэсэг, заалтыг үндэслэн Цэцэд хандаж байгааг тусгасан эсэх	Монгол Улсын иргэн Т миний бие Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсэг, Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг үндэслэн энэхүү мэдээллийг гаргаж байна.	0-3
	- мэдээлийн үндэслэл, бусад нөхцөл байдал, тэдгээрийн нотолгоог тусгасан эсэх	Шалгах үзүүлэлтийн 2-т тусгасан	
	- маргаж байгаа асуудлын талаархи өөрийн байр суурийг илэрхийлсэн илэрхийлсэн эсэх	Шалгах үзүүлэлтийн 2-т тусгасан	
	- Цэцээр шийдвэрлүүлэхээр тавьж байгаа шаардлагыг тодорхойлсон эсэх	Шалгах үзүүлэлтийн 3-т тусгасан	
	- хавсаргасан бичиг баримт дурдсан байдал	Мэдээлэлд хавсаргасан баримт: 1. Иргэний үнэмлэхний хуулбар 1 хуудас; 2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 2 дугаар тойрогт нэр дэвшигчээр бүртгүүлсэн үнэмлэх	
2	Өргөдөл, мэдээллийн хууль зүйн болон бусад үндэслэлийг тодорхойлсон байдал (ҮХЦМХШАмХ-ийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 5 дахь заалт)		

	<p>- Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн ямар зүйл, хэсэг, заалтыг үндэслэн Цэцэд хандаж байгааг бүрэн, зөв тодорхойлсон эсэх</p>	<p>Монгол Улсын иргэн Т миний бие Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсэг, Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг үндэслэн энэхүү мэдээллийг гаргаж байна.</p>	0-8
	<p>- мэдээллийн үндэслэл, бусад нөхцөл байдал, тэдгээрийн нотолгоог илэрхийлсэн байдал</p>	<p>Иргэн “Т” миний бие УИХ-ын сонгуулийн 2-р тойрогт нэр дэвшин бүртгүүлж, нэр дэвшигчийн үнэмлэх авсан өдрөөс сонгуулийн сурталчилгаагаа эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсоосон.</p>	
	<p>- маргаж байгаа асуудлын талаархи өөрийн байр суурийг илэрхийлсэн байдал</p>	<p>Сурталчилгааны хугацаанд би Говь-Алтай, Завхан аймгийн иргэд, сонгогчидтой л уулзалт, цуглаан хийсэн харин Увс, Ховд аймгийн сонгогчидтой уулзалт хийж амжаагүй тул эдгээр аймгаас хамгийн бага санал авсан.</p> <p>Би сонгуульд ялагдсан шалтгаанаа Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсгийн “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.”, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь нэр дэвшигчдэд тэгш бус нөхцөлийг бүрдүүлсэнтэй холбоотой гэж үзэж байгаа. Хуулийн дээрх зохицуулалтууд нь Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байгаа гишүүд дараагийн сонгуульд нэр дэвшиж байгаа тохиолдолд тэдэнд бусад өрсөлдөгчөөс д давуу байдал олгож, тайлан гэх нэрээр сурталчилгаа хийх, давуу эрх эдлэх бүхий л боломжийг нээж өгсөн.</p>	
	<p>Шаардлагаа тодорхойлсон байдал (УХЦМХШАмХ-ийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт)</p>		
3	<p>- Ямар хуулийн ямар зүйл, хэсэг, заалт Үндсэн хуулийн ямар зохицуулалтыг зөрчсөнийг даалгаврын өгөдөлд тусгасан агуулгын хүрээнд бүрэн зөв тодорхойлсон эсэх</p>	<p>Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт "Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.", 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт "Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Хүнийг ... албан тушаал ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...", Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад "... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ..." гэснийг тус тус зөрчсөн талаар дүгнэлт гаргаж өгнө үү.</p>	0-4
	<p>- Цэцээс ямар шийдвэр гаргуулах гэж байгааг зөв тодорхойлсон эсэх</p>		